


БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР



НИЙЛҮҮЛЭГЧ:

ОБ ПЛАСТИК ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.АМАРСАЙХАН



“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвд”

Хог хаягдлын уут нийлүүлэх гэрээ

2016 оны 2 сарын 22

Улаанбаатар хот

Нэг талаас “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ОБ пластик” ХХК (“цаашид нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 2 дугаар сарын 22-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч 5 төрлийн Хог хаягдлын уутыг 3925460 (гурван сая есөн зуун хорин таван мянга дөрвөн зуун жаран) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн 3,925,460 төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4. Нийлүүлэгч 5 төрлийн Хог хаягдлын уутыг 2016 оны 2 сарын 22-ноос 2016 оны 12 дугаар сарын 01-ний дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.
- 1.5. Дор дурьдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. (Цаашид гэрээний баримт гэх) Үүнд:
 - A. Гэрээ байгуулах тухай мэдэгдэл
 - B. Үнийн хуваарь
 - C. Гэрээний тусгай нөхцөл
 - D. Гэрээний ерөнхий нөхцөл
 - E. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь

Гэрээ нь энд дурьдсан бараа нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурьдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Захиалагч нь 1.4-т дурьдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 20 хоногийн дотор нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.

2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх алдангийг хэтрүүлсэн долоо хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах эрхтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.

3.2 Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу биоаюулгүйн таних тэмдэгтэй байна.

3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.

3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох асуудал гаргасан тохиолдолд 7 хоногт 0,5%-ийн алдангийг захиалагчид төлнө.

ДӨРӨВ. ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.


5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцэх боломжгүй болсон тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр З хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт: Судлалын Үндэсний

Төвийн Ерөнхий нягтлан бодогч Д.Гүнжээ



Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

УЗИБ01116

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Об пластик ХХК-ний

Менежер А.Түвшинбямба

ОБПЛАСТИК

ХХК

Хаяг: Хан-Уул дүүрэг,

3-р хороо, өөрийн байр

Утас: 88637903, 345571, Факс: 349999

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны үнийн хуваарь

огноо: 2016.02.22
НТШ-ЫН ДУГААР : 2016 он 02

ХОГ ХАЯГДЛЫН УУТ №03.

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу өрөнхий нэршил	Эмийн хэлбэр	Хэмжих нэгж	Шаардагдаж буй хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ (НӨАТ орсон)
1.	Улаан өнгөтэй, 100x60 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, бионаулгүй таних тэмдэгтэй	Waste bags	Туслах материал	Ширхэг	5000	132	660000
2.	Шар өнгөтэй, 60x50 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, бионаулгүй таних тэмдэгтэй	Waste bags	Туслах материал	Ширхэг	10000	66	660000
3.	Улаан өнгөтэй, 60x50 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, бионаулгүй таних тэмдэгтэй	Waste bags	Туслах материал	Ширхэг	10000	66	660000
4.	Хар өнгөтэй, 60x50 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай	Waste bags	Туслах материал	Ширхэг	12000	66	792000
5.	Хар өнгөтэй, 80x60 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай	Waste bags	Туслах материал	Ширхэг	7530	132	993960
6.	Хэв	Mold	Туслах материал	Ширхэг	1	159500	159500
Нийт							3925460

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ-ХОГ ХЯГДЛЫН УУТ

№	Бүтээгдэхүүний нэр	Эмийн олон улсын буоу ерөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савалалтын хэмжээ	Шаардагдаж буй хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь		
						2016 оны 2 сар	2016 оны 5 сар	2016 оны 8 сар
1.	Улаан өнгөтэй, 100x60 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, биоаюулгүй таних тэмдэгтэй	Waste bags	Туслах материал	Ширхэг	5000	5000		
2.	Шар өнгөтэй, 60x50 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, биоаюулгүй таних тэмдэгтэй	Waste bags	Туслах материал	Ширхэг	10000		2000	3000
3.	Улаан өнгөтэй, 60x50 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай, биоаюулгүй таних тэмдэгтэй	Waste bags	Туслах материал	Ширхэг	10000		2000	3000
4.	Хар өнгөтэй, 60x50 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай	Waste bags	Туслах материал	Ширхэг	12000		2000	3000
5.	Хар өнгөтэй, 80x60 хэмжээтэй, 2,5 микрон зузаантай	Waste bags	Туслах материал	Ширхэг	7650		1500	2000
6.	Хэв	Mold	Туслах материал	Ширхэг	1	1	-	-

Захиалагчийг төлөөлж :

Цус Сэлбэлт Судалын Үндэсний

Тооцооны няглан бодогч

Ц.Гадинжид *Ц.Гадинжид*

Лавлагaa лабораторийн тасгийн эмч

С.Хаян..... *С.Хаян*

Нийлүүлэгчийг төлөөлж :

Об пластик ХХК-ийг

Менежер

А.Түвшинбямба

А.Түвшинбямба